



ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2024 оны 07 дугаар сарын 29

Дугаар 17/04

Баян-Өндөр сум


Орон нутгийн өмчийн 2023 оны  
дүн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалт, 21 дүгээр зүйлийн 21.1.2 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1.18 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 2.2 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ НЬ:

1.Орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгийн 2023 оны жилийн эцсийн дүнг 630,964,212,708.8 (Зургаан зуун гучин тэрбум есөн зуун жаран дөрвөн сая хоёр зуун арван хоёр мянга долоон зуун найман төгрөг, найман мөнгө) төгрөгөөр, хавсралтын дагуу баталсугай.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит бус XVII хуралдаанаас тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэн ажиллаж, тайланг 2024 оны IV улиралд багтаан ирүүлэн ажиллахыг аймгийн Засаг дарга (М.Түмэнжаргал)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХБАТ